

*Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2009 оны 40 дүгээр тогтоолын  
хавсралт*



**МОНГОЛ УЛСЫН  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

# **ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2009-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**

**Улаанбаатар хот  
2009 он**

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын хөгжил нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өсөлт, хөгжлийг хурдасгагч, хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл хөшүүрэг хэмээн үзэж байгаа билээ. Иймээс ч Монгол Улсын Их хурлаар 2008 онд баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” баримт бичиг“-т .....мэдээлэл, харилцааны технологийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 21 дүгээр зууны үндсэн хурдасгуур гэж үзнэ (5.3.4. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн бодлого хэсэг)..... хэмээн үзэл баримтлалыг томъёолсон юм. Түүнчлэн “Цахим Монгол үндэсний хөтөлбөр” (2005), “Цахим Засгийн газар мастер төлөвлөгөө” (2005), Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны мөрийн хөтөлбөр (УИХ, 35 тоот тогтоол, 2008), “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” баримт бичиг (УИХ, 12 тоот тогтоол, 2008), “Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр” (2008), Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 77 тоот захирамж зэрэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратегийг боловсруулан гаргах үндсэн шаардлага болсон юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги нь манай улсын салбарын хөгжлийн болон техник технологийн цаашдын хандлага, бодлогын хүрээнд зохицуулалтын орчинг боловсронгуй болгох Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, гол зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон байгууллагын үнэт зүйлсийг баримтлан хэрэгжүүлэхээр тусгалаа. Энэхүү стратегийн үндсэн зорилго нь Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн хөгжлийн бодлого, стратегийн хүрээнд салбарын зохицуулалтын таатай орчинг бүрдүүлснээр мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтыг олон улсын жижигт хүргэж, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, мэдээллийн дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, цахим засаглалыг бий болгох, мэдээллийн нууцлалт, аюулгүй байдлыг хангах, шинэлэг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангасан мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг хүргэх нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байна. Энэхүү баримт бичигт ХХЗХ-ны үйл ажиллагааг улам боловсронгуй болгох зорилгоор эхний үе шатанд ажлын арга барилыг сайжруулах, цалин урамшууллын тогтолцоог шинэчилэх, чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагаагаа нийтэд сурталчилах, төлөвлөгөөт ажил, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны явц, хэрэгжилтийн үр дүн биелэлтэнд дотоод хяналт, шинжилгээ мониторинг хийх замаар үнэлэлт, дүгнэлт тогтмол өгөх замаар боловсронгуй болгох, төрийн бус байгууллага, иргэдтэй нягт хамтран ажиллах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарах болно.

Энэхүү стратеги, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, иргэд дэмжин бидэнтэй хамтран ажиллана гэдэгт гүнээ найдаж байна.

Хүндэтгэсэн,

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Б.БОЛДБААТАР

# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2009-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

## **1.0. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1.1. Оршил**

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) бол Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хуульд заасан Хорооны бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх бие даасан байгууллага юм.

ХХЗХ-ны 2009-2012 оны үйл ажиллагааны стратеги /цаашид “Стратеги” гэх/-т Монгол Улсын Засгийн газар болон Ерөнхий Сайдаас мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын асуудлаар баримтлах зохицуулалтын чиглэл, судалгаа боловсруулах, төлөвлөх, ХХЗХ-ноос гарсан тогтоол, шийдвэр болон зохицуулалтын үйл ажиллагаа, үйлчилгээний хэрэгжилтийг зохион байгуулах, зөвлөмжөөр хангах, олон нийтэд сурталчилах, иргэдийн хэрэгцээг хангасан үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлэх зэрэг асуудлыг хамарсан бие даасан ХХЗХ-ны үйл ажиллагааны стратегийг тодорхойлов.

ХХЗХ-ны үйл ажиллагаа нь Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжих бөгөөд төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэг, үйлчилгээтэй давхардаагүй болно.

### **1.2. Стратегийг боловсруулах үндэслэл**

Улсын Их Хурлын “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртлэх үзэл баримтлалыг батлах тухай” 2000 оны 21 дүгээр тогтоол, УИХ-аас 2001 онд баталсан Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хууль; УИХ-ын “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай” 2008 оны 12 дугаар тогтоол, УИХ-ын “Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны мөрийн хөтөлбөр батлах тухай” 2008 оны 35 дугаар тогтоол; Засгийн Газрын “Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги батлах тухай” 2002 оны 232 дугаар тогтоол, Засгийн газрын “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм батлах тухай” 2002 оны 15 дугаар тогтоол, Засгийн газрын “Цахим Монгол үндэсний хөтөлбөр батлах тухай” 2005 оны 11 дүгээр тогтоол, Засгийн газрын “Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр батлах тухай” 2008 оны 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэв.

### **1.3. Хууль тогтоомжийн орчин**

Стратегийг дор дурдсан хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Төсвийн удирдлага санхүүжилтийн тухай хууль;
- Монгол Улсын Харилцаа холбооны тухай;
- Монгол Улсын Шуудангийн тухай;

- Монгол Улсын Радио долгионы тухай хууль;
- Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль;
- Компаний тухай хууль;
- Тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

#### **1.4. Арга зүй**


Стратегийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага; үйл ажиллагаа (**бизнес**)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл; байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг тус тус хэрэглэв.

## **2.0. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2009-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**

### **2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар, загвар**

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2009-2012 оны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь УИХ-аас 2001 онд баталсан Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хуулийн Хоёрдугаар бүлгийн 8 дугаар, 9 дүгээр зүйлд тус тус заасан Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны бие даасан байдал, бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Ерөнхий Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, салбарын зохицуулалтын чиглэлээр бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратегийн загварын бүдүүвчийг үзүүлэв.



### **2.2. Үйл ажиллагааны эрхэм зорилго**

**Монгол Улсын нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийг дэмжсэн мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэхэд оршино.**

### **2.3. Үйл ажиллагааны стратегийн зорилтууд**

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын таатай орчинг бүрдүүлснээр эх орныхоо хөгжил цэцэглэлтийг түргэтгэх, үндэсний хөгжлийн хөшүүрэг хэрэгсэл болгох, иргэдэд орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурласан цахим хэрэглээ, үйлчилгээгээр хангах, шинэ эдийн засаг, “Мэдээлэлжсэн нийгэм”-ийн суурь үндсийг бүрдүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар МХТТ-ийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбар, хүн бүрийн өдөр тутмын хэрэгцээ, шаардлага болгоход үйл ажиллагааны стратегийн зорилт оршино.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь үйл ажиллагааны эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Мэдээлэл холбооны салбарын зохицуулалтыг олон улсын жишигт хүргэж, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих.
2. Мэдээлэлжсэн нийгмийн үндэс суурь болсон орчин үеийн, аюулгүй мэдээллийн дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх,
3. Хөгжил дэвшилд чиглэсэн шинэ санаа, шинэлэг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангахуйц үйлчилгээг хүргэх нөхцлийг бүрдүүлэх;

### **2.4. Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх үнэт зүйлс**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ дор дурдсан үнэт зүйлсийг баримтална:

- ❖ Шударга ёсыг эрхэмлэх;
- ❖ Ил тод, тунгалаг байдал;
- ❖ Хариуцлагатай, чадварлаг, шуурхай байх;

### **2.5. Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчмууд**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ дараахь үндсэн зарчмыг баримтлан ажиллана:

- ❖ Эдийн засгийн зохицуулалтанд илүү ач холбогдол өгөх,
- ❖ Үйл ажиллагаандаа байгууллагын үнэт зүйлсийг хэрэгжүүлэх,
- ❖ Монгол улсын иргэд хаана амьдарч байгаагаасаа үл хамааран мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээ, үйлчилгээг тэгш хүртэх,
- ❖ Техник, технологиос илүү үйлчилгээнд тэргүүлэх ач холбогдол өгөх,
- ❖ Нэгдмэл тусгай зөвшөөрөлд шилжүүлэх буюу нэг тусгай зөвшөөрөл-нэг сүлжээ- бүх үйлчилгээ (Unified licensing) зарчмыг баримтлах,

- ❖ Технологиос болон үйлчилгээ олгогчоос үл хамаарсан (Technology neutral, provider neutral),
- ❖ Олон улсын байгууллагын зөвлөмж, гадаад улс орны хөгжлийн туршлагаас суралцах зэрэг болно.

## **2.6. Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх үе шат**

Үйл ажиллагааны стратегийг Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2009-2012 онд хэрэгжүүлэх бөгөөд жил бүрийн тус хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулах Ерөнхий менежерын гэрээний салшгүй хэсэг байна.

## **2.7. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гол зорилт, арга хэмжээнүүд**

Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратегийн эрхэм зорилго, зорилт болон арга хэмжээг байгууллагын үнэт зүйлс дээр үндэслэн дараахь үйл ажиллагааны гол зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөгжлийн бодлог стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник, технологиуд, түүний нэгдэн нийлэлт нь салбарын зах зээлд үйлчилгээний өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчид болон олон нийтэд хэрэгцээт шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээний хүртээмжийг бий болгох чухал хэрэгсэл болгоно. Шинэ технологи, цахим хэрэглээ үйлчилгээ нь хөгжлийн нааштай үр дүн, нөхцөл байдал, хүчин зүйлсийг бий болгодог боловч бизнес, хувь хүмүүст учрах тодорхой хэмжээний эрсдлийг саармагжуулах зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Сүүлийн үеийн дэвшилт технологийн нэвтрэлт, үнэ тарифын бууралт, зах зээлийг чөлөөтэй болгох, хэрэглээний зах зээлийг дэмжих, төр ба хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалт хийх зэрэг арга хэмжээнүүд нь алслагдсан орон нутагт хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бий болгож байна. Шинэ мөртлөө боломжийн хямд өртөгтэй техник хэрэгсэл, утасгүй холбоо, МХХТ-ийн үйлчилгээний жижиглэн худалдаалах шинэ арга, олон нийтэд хүртээх цаг хугацаа зэрэг нь мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ хэрэглээг улам бүр хүртээмжтэй болгосоор байна. Үүний зэрэгцээ, өндөр өртөгтэй болон зах хязгаар нутгийн үйлчилгээний хамралтын хүрээг өргөжүүлэх үүднээс урамшуулал болон тодорхой нөхцөл тавих зэргээр зохицуулалтын хүрээнд арга хэмжээг үргэлжүүлнэ.

**Гол зорилт-1.** Мэдээлэл, харилцаа холбооны техникийн зохицуулалтын орчинг боловсронгуй болгоно.

*Техникийн зохицуулалтын талаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүд.*

*1.1.Харилцан холболт:*

- ❖ Харилцаа холбооны сүлжээний харилцан холболтын тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоон мөрдүүлнэ.
- ❖ Сүлжээ хоорондын техникийн харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, шаардлага, зааглах цэгийг тогтоох, гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавина.
- ❖ Засгийн газрын бодлогын хүрээнд шинэ техник, технологийн ололтыг нэвтрүүлэх зохицуулалтын дүрэм, журам, чиглэл боловсруулан мөрдүүлнэ (IP Backbone network, NGN, 4G, IPTV, Mobile TV)
- ❖ Шуудангийн нэгдсэн код, хаягжилтын тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжилтэнд хяналт тавина.

### *1.2.Тусгай зөвшөөрөл:*

- ❖ Тусгай зөвшөөрлийн ангилал, нөхцөл шаардлага, олгох үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
- ❖ Нэгдмэл тусгай зөвшөөрөлд шилжүүлэх буюу нэг тусгай зөвшөөрөл-нэг сүлжээ- бүх үйлчилгээ (Unified licensing) нэвтрүүлэх талаар судалгаа хийж, санал боловсруулна.
- ❖ Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг хангуулна.
- ❖ Зах зээлд шинээр үйлчилгээ нэвтрүүлэх, шудрага өрсөлдөөнийг хангахад чиглэсэн тусгай зөвшөөрлийн тогтолцоог бүрдүүлнэ.

### *1.3.Дугаарлалт:*

- ❖ Тусгай зөвшөөрөл эзэмшигч үндэсний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар шинэчилэн мөрдүүлнэ.
- ❖ Газар зүйн бүсээс үл хамаарсан дугаарлалтыг нэвтрүүлнэ.
- ❖ Дугаарлалтын нөөцийг үр ашигтай ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.

### *1.4.Стандартчилал, баталгаажуулалт:*

- ❖ Мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын стандартуудын хэрэгжилтэнд хяналт тавих, шаардлагатай шинэчлэлийг хийх;
- ❖ Дараа үеийн сүлжээ, тоон радио телевизийн өргөн нэвтрүүлэг, мэдээллийн технологи, агуулгын зохицуулалтын болон шинэ техник технологийн чиглэлээр холбогдох стандартуудыг боловсруулж мөрдүүлнэ.
- ❖ Бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, орон зайн мэдээлийн дэд бүтэц, хаягжуулалтын үйлчилгээ, хэрэглээний стандартыг боловсруулан мөрдүүлнэ.
- ❖ Баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх дүрэм, журам боловсруулна.
- ❖ Мэдээллийн технологи, электроникийн техник, хэрэгслийн үйлдвэрлэлийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

**Гол зорилт-2.** Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, мэдээллийн технологийн хэрэглээ ба өргөн нэвтрүүлгийн сүлжээний зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

*Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд.*

*2.1. Мэдээлэл, холбооны дэд бүтэц:*

- ❖ Шинэ үеийн (IP, DWDM network, Ring, Core Data network) дэд бүтцийн сүлжээ байгуулах, бүсчилэх цагираг хэлбэрт шилжүүлэхэд дэмжинэ.
- ❖ Өндөр хурдны, өргөн зурвасын сүлжээ, интернэтийн дамжлага бүхий 2 дахь гарцыг бий болгох зохицуулалтын орчныг бүрдүүлнэ.
- ❖ Мэдээлэл холбооны дэд бүтэц, суурь сүлжээг ашиглан шуудангийн мэдээллийн сүлжээг зохион байгуулах, цахим хэлбэрт шилжүүлэх, цахим маркийн үйлчилгээг нэвтрүүлэх зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ❖ Төрөл бүрийн дамжуулах сүлжээг харилцан ашиглах, хуваалцах, сүлжээг нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлнэ.
- ❖ Дараа үеийн сүлжээ-NGN, нууцлалт, сүлжээний аюулгүй байдлыг хангах нөхцөл, шаардлагыг боловсруулна.

*2.2. Мэдээллийн технологи ба хэрэглээ, үйлчилгээ:*

- ❖ Үндэсний өгөгдөл мэдээллийн төв, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцооны хүрээнд төрийн цахим үйлчилгээ, сүлжээний аюулгүй байдал, хэрэглээний дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлнэ.
- ❖ МХТТ-ийн шинэ хэрэглээ, шинэ цахим буюу э-үйлчилгээнүүдийг зохицуулалтын хөшүүргээр дэмжих, (э-засгийн газар, э-худалдан авалт, э-татвар, э-бүртгэл гэх мэт)-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- ❖ Цахим арилжаа, цахим худалдаа, цахим эмнэлэг, цахим банкны үйлчилгээ ба хэрэглээний худалдааг хялбаршуулна.
- ❖ Зайн сургалт, зайн эмчилгээ, боловсролын сүлжээ, цахим шуудангийн үйлчилгээ бүрдүүлэхэд зохицуулалтын талаар дэмжлэг үзүүлнэ.
- ❖ Програмын хангамж, агуулгын зохицуулалтын орчинг бүрдүүлнэ. (Outsourcing, Content regulation)
- ❖ Интернэтийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээ, хэрэглээг дэмжих зохицуулалтын орчинг бүрдүүлнэ.
- ❖ Домайн нэрийн зохицуулалтыг сайжруулна.
- ❖ Мэдээллийн технологид суурилсан шуудангийн үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлнэ.

*2.3. Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг:*

- ❖ Радио, телевизийн зах зээлийн өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээг тогтоон мөрдүүлнэ.
- ❖ Тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээнд шилжүүлэх судалгааг хийж зохицуулалтын арга хэмжээг боловсруулна (digital TV broadcasting, IPTV)
- ❖ Тоон радио өргөн нэвтрүүлгийн сүлжээнд шилжүүлэх судалгааг хийж, зохицуулалтын арга хэмжээг боловсруулна (Digital radio broadcasting)
- ❖ Үндэсний хиймэл дагуул хөөргөх судалгааг хийнэ.
- ❖ Багц дамжууллын технологи хэрэглэсэн олон төрлийн телевизийн үйлчилгээний зохицуулалтыг бий болгоно

**Гол зорилт-3.** Салбарын эдийн засгийн зохицуулалтыг төгөлдөршүүлнэ.

*Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд.*

**3.1. Өрсөлдөөн:**

- ❖ Салбарын хөгжлийн бодлого, стратегийн хүрээнд мэдээлэл, харилцаа, холбоо, шуудангийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ❖ Өрсөлдөөний зохицуулалтын баримт, бичгүүдийг боловсруулан мөрдүүлнэ.
- ❖ Сүлжээ, үйлчилгээг салгах бодлогын хэрэгжилтэнд шинжилгээ хийж, боловсронгуй болгох аргачлал зөвлөмжийг гаргана.

**3.2. Харилцан холболт:**

- ❖ Нэг платформоос олон платформ бүхий үйлчилгээний нөхцлүүд, харилцан холболтын эдийн засгийн шинэ загварыг боловсруулна. (Тухайлбал, өөр төрлийн сүлжээнүүдийн хоорондох харилцан холболт, сүлжээний хэсгүүдийг хэсэгчлэн түрээслэх шинэ хэлбэр бий болгох)
- ❖ Шинэ харилцан холболтын загварыг нэвтрүүлэх, багц технологид шилжүүлэх шилжилтийн үеийн зохицуулалтын баримт бичиг боловсруулна.

**3.3. Үнэ тарифын зохицуулалт:**

- ❖ Мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн зах зээл дэх өрсөлдөөний байдал, хандлагад судалгаа шинжилгээ хийж, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ❖ Харилцан холболтын хөлс тогтоох аргачлал, орлого хуваарилах зохицуулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- ❖ Суурин, үүрэн холбоо болон шуудангийн үнэ тарифын зохицуулалтыг сайжруулна.
- ❖ Ижил эсвэл маш төстэй үйлчилгээнүүдийг өөр өөр үнэ өртөг бүхий дэд бүтцээр дамжуулах зарчмыг бий болгоно.
- ❖ Зохистой худалдаа, хөрөнгө оруулалтын механизмыг хөнгөвчилнө.

**Гол зорилт-4.** Радио давтамжийн төлөвлөлт, удирдлага зохицуулалт, хяналт мониторингийн тогтолцоог сайжруулна.

*Хэрэгжүүлэх арга хэмжээ.*

**4.1. Радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалт:**

- ❖ Радио давтамжийн төлөвлөлтийг утасгүй сүлжээний шинэ технологудтай уялдуулан шинэчилэх
- ❖ Радио долгионы спектр ашиглалтыг нэмэгдүүлэх технологи бүхий системүүдийг судлан нэвтрүүлэх чиглэл барьж ажиллах
- ❖ Монгол Улсад ашиглаж байгаа радио тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлнэ

#### 4.2. Тусгай зөвшөөрөл:

- ❖ Радио долгионы тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг шинэчилнэ.
- ❖ Утасгүй холбоо, хөдөлгөөнт холбооны шинэ технологи, тоон радио телевизийн өргөн нэвтрүүлгийн давтамжийн төлөвлөлтийг шинэчилэн боловсруулна.

#### 4.3. Хяналт, мониторинг:

- ❖ Радио давтамжийн хяналтын тогтолцоог үр ашигтай ашиглах, боловсронгуй болгох арга хэмжээг авна.
- ❖ Радио давтамжийн мэдээллийн санг бүрдүүлэх, хяналт шалгалтыг тогтмолжуулна.

**Гол зорилт-5.** Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлэх, байгууллагын хөгжлийг дэмжиж ажиллана.

*Хэрэгжүүлэх арга хэмжээ.*

#### 5.1. Үйлчилгээний чанар:

- ❖ Хууль эрх зүйн хүрээнд үйлчилгээний чанарын үзүүлэлт, нөхцөл шаардлагыг тодорхойлон мөрдүүлнэ.
- ❖ Монгол Улсын хот, хөдөөгийн хоорондох тоон хуваагдлыг багасгах, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг жил бүр тодорхойлон хяналт тавина.
- ❖ Бүх нийтийн үйлчилгээний нөхцөл, шаардлагыг боловсруулан хэрэгжилтэнд хяналт тавина.

#### 5.2. Хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах:

- ❖ Харилцаа холбооны асуудлаар хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллана.
- ❖ Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах, мэдээллийн нууцлалтыг хангаж ажиллана.
- ❖ Иргэдээс зохицуулалтын үйлчилгээний талаар мэдээлэл нээлттэй авах, нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааг нэвтрүүлнэ.

#### 5.3. Гомдол маргаан шийдвэрлэх:

- ❖ Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргаан болон хэрэглэгчийн эрх ашгийг хөндсөн маргаантай асуудлыг судлан тухай бүр шийдвэрлэнэ.
- ❖ Маргаан, гомдлыг шийдвэрлэх талаар холбогдох яам, байгууллагатай хамтран ажиллана.

- ❖ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог бүрдүүлнэ.

#### 5.4. Байгууллагын хөгжлийг дэмжих, чадавхийг бүрдүүлэх:

- ❖ Байгууллагыг уян хатан, оновчтой, мэдлэгт тулгуурласан байгууллага болгох, шинэ санаа, бүтээлч үйл ажиллагааг дэмжинэ.
- ❖ Байгууллагын үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэм болон бусад баримт бичгийг шинээр боловсруулан /Code of practice, code of conduct/ мөрдүүлнэ.
- ❖ ХХЗХ-ны тогтоол шийдвэр, зохицуулалтын бодлого боловсруулах, төлөвлөлт, зохицуулалтын үйлчилгээний хэрэгжилтэнд тогтмол дотоод хяналт, шинжилгээ мониторинг хийж, үйл ажиллагаандаа дүгнэлт өгч ажиллана.
- ❖ Хорооны ажилтнуудыг сургалтад гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтанд хамруулан мэргэшүүлэх замаар байгууллагын чадавхийн дээшлүүлнэ.
- ❖ Байгууллагын ажилтан, ажиллагсдын нийгмийн асуудлын талаар санал боловсруулж шийдвэрлэн ажиллана.

#### 5.5. Гадаад хамтын ажиллагаа ба бусад:

- ❖ Олон улсын болон бүс нутгийн цахилгаан холбоо, мэдээллийн технологи, шуудан холбооны байгууллага, гадаад улсын зохицуулах байгууллагатай идэвхитэй хамтран ажиллаж санамж бичиг байгуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх
- ❖ Олон улсын болон бүс нутгийн мэдээлэл, цахилгаан холбоо, шуудан холбооны байгууллагаас зохион байгуулж байгаа хурал, семинар, зөвлөлгөөнд тогтмол оролцож Монгол Улсын нэр хүндийг дээшлүүлэх
- ❖ Хорооны шийдвэр, харилцаа холбооны салбарын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, салбарын зах зээл, нэвтэрч байгаа шинэ үйлчилгээний талаар тогтмол сурталчилна.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын бодлого, зохицуулалт, техник технологийн хөгжлийн хандлагын талаар судалгаа шинжилгээний төсөл, арга хэмжээг багтаасан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- ❖ Хорооны тогтоол, шийдвэр болон байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, шудрага явуулах, зохицуулалтын үйлчилгээний шуурхай хүнд сурталгүй хэрэгжүүлж, олон нийтэд сурталчилах арга хэмжээг зохион байгуулна.
- ❖ Хорооны үйл ажиллагааг төгөлдөршүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллана.
- ❖ Хорооны жилийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, төсвийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

### **3.0. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР**

#### **3.1. Үйл ажиллагааны өнөөгийн бүтэц зохион байгуулалт**

ХХЗХ-ны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь Хорооны хуралдаан байх ба тус хорооны 2002 оны 01 тогтоол, 2007 оны 14 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг мөрдөнө. Хорооны хуралдаанаар тогтоол, тэмдэглэл зэрэг шийдвэрийг гаргах бөгөөд түүний үндсэн үүрэг нь салбарыг хөгжүүлэх төрийн бодлого, стратегийг үндэслэн зохицуулалтын оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх, мөрдүүлэх замаар тус байгууллагын үндсэн зорилгыг хэрэгжүүлэх явдал юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны албад нь Засгийн газрын 2002 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн хүрээнд дараахь үндсэн эрх, чиг үүргийн хэрэгжүүлж байна:

- 1. Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба:** гэрээ, эрх зүйн талаарх зөвлөлгөө, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хяналт шалгалт, мөрдөлт, гомдол маргаан шийдвэрлэх, олон нийттэй харьцах, захиргаа болон санхүүгийн үйл ажиллагаа, гадаад хамтын ажиллагаа, хүний нөөцийн хөгжил болон сургалт, байгууллагын веб сайтын менежмент;
- 2. Зохицуулалтын алба:** тусгай зөвшөөрөл, стандарт болон баталгаажуулалт, харилцан холболтын техникийн асуудлууд, дугаарлалт, техникийн нөхцөл шаардлага, технологийн шинэчлэл, нэгдэл болон интернет;
- 3. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба:** радио давтамж төлөвлөлт, техникийн дүн шинжилгээ, радио давтамж хуваарилалт болон менежмент, радио давтамжийн хяналт шалгалт, радио долгион ашиглах тусгай зөвшөөрөл болон өргөн нэвтрүүлэг;
- 4. Зах зээл, үнэ тарифын алба:** зах зээлийн стратегийн дүн шинжилгээ, зах зээлийн судалгаа болон статистик мэдээлэл, үнэ тариф, харилцан холболтын төлбөр, өрсөлдөөн, бүх нийтийн үйлчилгээний үүргийг тодорхойлох;
- 5. Шуудангийн алба:** шуудангийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, зип код, хаягжуулалт, харилцан холболт, үнэ тариф зэрэг болно.

Харилцаа холбооны зохицуулах хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлж хэрэгжүүлсэн төслийн тайлан баримт бичигт тус хорооны бүтцийг боловсронгуй болгох, шинэчилэх талаар санал, зөвлөмжийг боловсруулсан байна. Гэвч эдгээр санал, зөвлөмжүүд нь нэлээд нарийвчлан судалж шийдвэрлэх асуудал юм.

#### **3.2. Үйл ажиллагааны стратегийн хүрээнд ойрын үед хэрэгжүүлэх арга хэмжээ**

Олон улсын байгууллага, дотоодын зөвлөхүүдийн төсөл хөтөлбөрийн хүрээнд өгсөн зөвлөмж, одоогийн практикаас харахад зохицуулалтын үйл ажиллагаа явуулахад зарим хүндрэл гарч байгаа болно. Тухайлбал:

- Зохицуулалтын бодлого, төлөвлөлт болон хэрэгжилтийг бүтцийн хувьд ялган зааглах шаардлага байна. Өнөөгийн нөхцөлд зохицуулалтын өдөр тутмын үйл ажиллагаанд голлон анхаарснаас зохицуулалтын бодлого, төлөвлөлтийн асуудал хоцрогдолтой байна. Энэ нь тус салбарт бий болж байгаа өөрчлөлт, шинэ үйлчилгээнүүдийн зохицуулалтыг хийхэд хүндрэл учруулж байна.
- Шинэ технологи, шинэ зах зээл, үйлчилгээ бий болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлж, зохицуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2009-2012 оны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээг эхний үе шатанд авна. Үүнд:

- Хорооны одоогийн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд албадын хариуцсан ажил, эрх үүргийн давхардал, ажлын заагийг тодорхой болгох, иргэдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний үйл ажиллагааны процессыг загварчлах, шинэчилэн боловсронгуй болгоно. Тухайлбал: Хорооны хуралдаанд оруулах асуудлыг хэлэлцүүлэх процессын үе шатыг сайжруулах, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, шийдвэрийн хэрэгжсэн биелэлт, Даргын шуурхай зөвлөгөөний үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвлөмж өгөхөөс эхлээд шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх хүртэл нээлттэй, хурдтай, хүнд сурталгүй явуулах шинэ иж бүрэн цикль процесс болгон загварчлах г.м
- Байгууллагын үйл дотоод ажиллагаа, ажлын арга барилыг сайжруулах, ажилтнуудыг тогтмол хугацаанд аттестачлах, цалин урамшууллын тогтолцоог ажлын ачаалал, цаг ашиглалт, идэвхи зүтгэл, шинэ санаачилга, үр дүнд тулгуурлан шинэчилэх, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилэх зэрэг чиглэлээр байгууллагын дотоод журам, холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах, замаар шийдвэрлэнэ.
- Байгууллагын дотоод хяналт, төлөвлөгөөт ажил, хөтөлбөрийн үйл ажиллагааны явц, хэрэгжилтийн үр дүн биелэлт, Хорооны шийдвэр болон Даргын тушаалын хэрэгжилтэнд тогтмол хяналт, шинжилгээ мониторинг хийх замаар үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.
- Байгууллагын үйл ажиллагаа, Хорооны болон Даргын тогтоол шийдвэр, тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилт, түүний үр дүнгийн талаар олон нийтэд ухуулан таниулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.
- Шаардлагатай тохиолдолд Засгийн газрын 2002 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ХХЗХ-ны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бүтцийн загварыг шинэчилэх зэрэг болно.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын чадавхийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

**Байгууллагын чадавхи.** Харилцаа холбооны зохицуулах хорооны чадавхийг бүрдүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор 2009-2012 онд тус байгууллагыг уян хатан, оновчтой, мэдлэгт тулгуурласан байгууллага болгоно:

- Урьдчилан харах замаар байгууллагад бодит хохирол учруулахаас нь өмнө арга хэмжээ авах.
- Үр ашигтай үйл ажиллагаа, шинэчлэл хоёрыг хослуулах.
- Үйл ажиллагаа явуулахдаа өөрчлөлтөөс өрсөх чадварыг нэмэгдүүлэх.
- Байгууллагын үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэм болон бусад баримт бичиг боловсруулан /Code of practice, code of conduct/ мөрдүүлэх зэрэг болно.

ХХЗХ нь салбарын бүх харилцагчтай хамтран ажилласнаар ард иргэддээ тустай дэлхийн жишигт хүрсэн МХХТ-н салбарыг бий болгоход туслах идэвхитэй, эрч хүчтэй, урагшлан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Шинэ санаа, бүтээлч үйл ажиллагааг дэмжих нь ийм уур амьсгалыг бүрдүүлэх арга хэрэгсэл нь байх болно.


**Судалгаа, шинжилгээний хөтөлбөр.** ХХЗХ-ны судалгаа, шинжилгээний ажлууд нь өргөн нэвтрүүлэг, мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлээр зохицуулалтын тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана. Судалгаа, шинжилгээний үндсэн чиглэл нь дараахь сэдвүүдийг хамарна:

- Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хандлага, байдал, тэдгээрийн хэрэглээг судлах.
- Үйлчилгээг даган бий болж байгаа зах зээлийн хандлага, нийлүүлэгчдийн талаарх судалгаа.
- Технологи, техникийн хөгжлийн хандлага, туршлага
- Эдийн засгийн шинжилгээ болон зохицуулалтын орчин
- Бусад зэрэг болно.

### **3.3. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар**

Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн цаашид тус хорооны үйл ажиллагааны дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг баримтлахыг санал болгож байна:

## ХХЗХ-ны үйл ажиллагаа (бизнес)-ны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



### **4.0. ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2009-2012 онд нийтдээ 8,28 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 5,75 тэрбум төгрөгийн зардал гаргахаар орлого, зарлагын төсвийн төсөөлөл, тооцоо судалгааг боловсруулав.

2009-2012 онд 4,62 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ба жил бүрийн төлөвлөгөөний төслийг үзүүлэв.

Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай жил бүрийн орлого төвлөрүүлэх, зардлын төсөв, хөрөнгө оруулалтын төсөөллийн тооцоог нэгтгэн боловсрууллаа (хавсралт-1 үзнэ үү).

Үйл ажиллагааны стратегийн эрхэм зорилго, стратегийн зорилт, гол зорилтууд болон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

ТӨГСӨВ.